



**МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7
Утас: 32-71-99, Факс: (976-11) 32-21-47
<http://www.ulaanbaatar.mn>

2020. 03. 02 № 02-01/1020

танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД**

Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны
03 дугаар сарын 02-ны өдрийн өргөтгөсөн хурлын
07 дугаар тэмдэглэлийг хүргүүлэв.

Хурлын шийдвэрийн биелэлтийг заасан
хугацаанд ирүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг
үүрэг болгож байна.

Хавсралт ⁵... хуудастай

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР
ОРЛОГЧ **Ж.БАТБАЯСГАЛАН**



D:\2020 on\1. Alban bichig\A-5 ZD.docx

1110200000340



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Нийслэлийн Онцгой комиссын 7 дугаар хурал /өргөтгөсөн/ 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 11:00 цагт Хангарди ордны хурлын Их танхимд гишүүдийн 97.2 хувийн ирцтэйгээр хуралдав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдварын /КОВИД-19/ шинээр үүссэн нөхцөл байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээ;
2. Авто замын хөдөлгөөний зохицуулалт;
3. Нутгийн захиргааны байгууллагын зарим албан хаагч нарт орон тооны бус байцаагчийн эрх олгох асуудал;
4. - Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний нөөц хангалт;
-Золбин нохой, муур устгалын ажлын явц, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ;
5. Эмзэг бүлгийн иргэдийг коронавируст /КОВИД-19/ халдвараас сэргийлж, зохион байгуулалтын арга хэмжээ авах ажил;
6. Коронавируст /КОВИД-19/ халдвараас урьдчилан сэргийлж, ажиглалтад байлгах иргэдийг байрлуулах сувиллын газар, бусад объектуудын судалгаа гарах, бэлэн байдлыг хангуулах;
7. Жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар тус тус хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт

- Коронавируст /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх талаар авч буй арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг амралт, сувиллын газар, зарим хувийн эмнэлгийн байгууллагуудыг ажиглалт, тандалтын байраар ашиглах, эм эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнсний үйлчилгээний тооцоог 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн дотор судлан шийдвэрлэж санал танилцуулах.

- Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл судалгааг 2020 оны 03 дугаар сарын 08-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэхэд шаардлагатай хүн хүчийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас бүрдүүлж хэрэгжилтийг хангах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст

- Иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл судалгааг зохион байгуулан ажиллаж байгаа бүрэлдэхүүний хоол унаа, бусад холбогдох зардлын тооцоог гаргаж Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэх.

Нутгийн захиргааны байгууллагуудад

- Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжиж, ажлын тусгай горимоор ажиллаж байгаатай холбогдуулан байгууллага бүрийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийх, ажилтан албан хаагчдын утсан харилцааны бэлэн байдлыг хангах, уртасгасан цагаар ажиллах, ажилдаа хариуцлагатай хандахыг үүрэгжүүлж, хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөц бүрдүүлэн 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор нийслэлийн Онцгой комисст ирүүлэх.

Дүүргүүдийн Засаг дарга,
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
Нутгийн захиргааны байгууллагуудын дарга нарт

- Нийслэлийн Засаг даргын 2020 оны “12 хүртлэх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг хорогдуулах тухай” А/268 дугаар захирамжийг хэрэгжүүлж, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлээ хамгаалах ажлыг дэмжиж зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Нийслэлийн Зам тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч,
Нийслэлийн Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар,
Нийслэлийн Нийтийн тээврийн үйлчилгээний газарт

- Авто машин, нийтийн тээврийн хэрэгслээр зорчих хөдөлгөөнд тавих хяналтыг үргэлжлүүлэн зохион байгуулах, нийслэлд зорчих авто машины хөдөлгөөнд зохицуулалт хийж хөдөлгөөний зөв зохион байгуулалтыг хангаж ажиллах.

- Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор орох гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөний ачаалал зохицуулах зохион байгуулалтын арга хэмжээнд авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай зохицуулалтыг хийж, түргэн шуурхай нэвтрэх боломж нөхцөлийг хангах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс,
Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт

- Нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрт эрүүл ахуй, орчны аюулгүй байдлын стандартын хяналтыг тавих байцаагчийн эрх олгох асуудлыг яаралтай судалж, олон нийтийн цагдааг тогтмол ажиллуулах асуудлыг 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн дотор тодорхой болгож шийдвэрлэх.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба,
Нийслэлийн Хүнс хөдөө аж ахуйн газарт

- Коронавируст /КОВИД-19/ халдварын талаар худал ташаа мэдээлэл иргэдийн дунд үүсэж, зохиомол хүнсний хомсдол үүсэхээс сэргийлэх, дотоодын хүнсний хангамжийн нөөц бүрдүүлэлт, нийлүүлэлтийн тооцоо судалгааг гаргаж, томоохон

үйлдвэр үйлчилгээний байгууллагуудтай хамтран ажиллах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал танилцуулж зохион байгуулалтын арга хэмжээ авах.

- Мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, золбин муур нохой устгалын ажлыг дүрэм журмын хүрээнд зохион байгуулж сэг зэмийг устган халдваргүйтгэл хийж, орчны эрүүл ахуйн хяналтыг чангатгах.

Нийслэлийн Эрүүл мэндийн газарт

- Хот хоорондын замын хөдөлгөөний хязгаарлалтыг нээсэнтэй холбогдуулан авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодоор нэвтрэх иргэдээс нэг бүрчлэн асуумж лавлагааг авч, биеийн халууныг хүн нэг бүрээр нарийвчлан үзэх, эрүүл мэндийн хяналт тандалтыг үр дүнтэй зохион байгуулах хүн хүчийг нэмэгдүүлж, постод хамт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдыг удирдлагаар хангах ажлыг хариуцан ажиллах.

Нийслэлийн Нийгмийн халамжийн газар, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Нийгмийн хамгааллын тусгай төвд

- Нийслэлд орон гэргүй, гадуур амьдардаг иргэдийн судалгааг дахин нарийвчлан гаргаж, түр байрлуулах арга хэмжээг зохион байгуулж, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, холбогдох санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх.

- Нийгмийн хамгааллын тусгай төвийн үйл ажиллагааг өргөжүүлж иргэд хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийслэлийн 2020 оны төсөвт тусгасан орон гэргүй гадуур амьдардаг иргэдийг орон байраар хангах төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төсөл, хөтөлбөрийн хяналт, зохицуулалтын хэлтэс, Нийслэлийн Шинжлэх ухаан үйлдвэрлэл инновацын газар, Нийслэлийн Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвд.

- Хотын эдийн засгийг дэмжих ажлын хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжих амны хаалт, хамгаалах хувцас оёж үйлдвэрлэх, бусад төрлийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйлдвэрлэгч, нийлүүлэгчдэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг туслалцааг олгох, зээл тусламжаар хангах холбогдох байгууллагуудтай хамтран тооцоо судалгааг хийж, нийслэлийн төсвийн боломжит эх үүсвэрээс гаргах ажлыг судалж 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн дотор танилцуулах.

- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг олон улсын байгууллага гадаад дотоодын хөрөнгө оруулагчтай хамтарч санал солилцох ажлыг зохион байгуулах.

Нийслэлийн Мал эмнэлгийн газарт

- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо Хөндлөн уулын ард, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны Баруун туруу товчоонд барьж байгаа мал эмнэлгийн хяналт халдваргүйтгэлийн цэгийн байрыг яаралтай дуусгах, Багануур дүүргийн мал эмнэлгийн халдваргүйтгэлийн цэгийг сайжруулж ашиглалтад бүрэн оруулах, ариутгал халдваргүйтгэл хийх нөхцөлийг хангах.

- 2020 онд төсөвлөгдсөн Хан-Уул дүүргийн 13 дугаар хороо Таван толгойд барих ариутгал халдваргүйтгэлийн байрны ажлыг эхлүүлж, яаралтай дуусгах ажлыг зохион байгуулах.

- Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, нүүдлийн шувууд ирэх үеийн тандалтыг зохион байгуулах, суурин аж ахуй, тэжээвэр амьтанд тавих эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангуулах, зэрлэг мал амьтдын хөл хөдөлгөөнд хяналт тавих ажлыг сайжруулах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,
Нийслэлийн Соёл урлагийн газар,
Нийслэлийн Боловсролын газарт

- Олон нийтийн сүлжээ хэвлэл мэдээллийн байгууллага, урлаг соёл, спорт, нийгэм эдийн засгийн салбарын төлөөллүүдтэй хамтран иргэдийг халдварт өвчнөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх зөвлөмжийг өгөх хотын соёлын зөв дадал зуршилд иргэдийг уриалах, үлгэрлэх ажилд хамтран ажиллах асуудлуудыг судалж шийдвэрлэх.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба,
Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар,
Нийслэлийн Онцгой байдлын газар,
Нийслэлийн Эрүүл мэндийн газар,
Нийслэлийн Мал эмнэлгийн газарт

- Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоод, аж ахуй нэгж, албан байгууллагууд болзошгүй халдварын үед ариутгал халдваргүйтгэлийн ажил зохион байгуулах шийдлүүд, тоног төхөөрөмж, зам гудамж талбайд ариутгал хийх бодисын нөөц бүрдүүлэх, сүүлийн үеийн технологийн шийдлийг боловсруулан 2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт танилцуулах.

Нийслэлийн Зам тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч,
Нийслэлийн Агаар орчны бохирдлын асуудал хариуцсан төслүүдийн удирдагч,
Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба,
“Таван толгой түлш” ХХК-нд

- Цаг агаар дулаарч айл өрхүүд сайжруулсан шахмал түлшний хэрэглээ багасаж байгаатай холбогдуулан түлш борлуулах цэгүүдийг тасралтгүй түлшээр хангах, түлш хадгалах, битүүмжлэл сайтай дундын болон хангамжийн баазуудад нөөц бүрдүүлэх ажлыг сайтар зохион байгуулах.

- Сайжруулсан түлшний 2 дах үйлдвэрийг Налайх дүүрэгт барих Засгийн газрын шийдвэр гарсантай холбогдуулан үйлдвэр барих газрын асуудлыг 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн дотор эцэслэн шийдвэрлэж танилцуулах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар,
Нийслэлийн Онцгой байдлын газар,
“Таван толгой түлш” ХХК-нд

- Зэвсэгт хүчний Жанжин штаб, Онцгой байдлын байгууллагын туулах чадвар сайтай авто машинаар өндөрлөг бүсэд байрлах айл өрхүүдэд сайжруулсан түлшний түгээлтийг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр хүртэл сунгаж үргэлжлүүлэн ажиллуулах гэрээ байгуулж хэрэгжилтийг хангуулах.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү төрийн сангийн хэлтэс,
Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газарт

- Зэвсэгт хүчний Жанжин штаб, Онцгой байдлын байгууллагаас өндөрлөг цэгүүдэд түлш түгээлт явуулж байгаа авто машины шатах, тослох материалын 1, 2 дугаар сарын зардлын тооцоог яаралтай нийлж, гэрээ сунгаж ажиллуулах хугацааны зардлын асуудлуудын тооцоо судалгааг гарган шийдвэрлэж ажиллах.

ДАРГА



С.АМАРСАЙХАН

